**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2025/113/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 **Цахим хаяг:** enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 **Цахим хаяг:** batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК
Утас:99052418 **Цахим хаяг:** cheegii9989@gmail.com


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# АГУУЛГА


1. АУДИТЫН ДҮГНЭЛТ ..... 3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 11
3.2.Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.. 12
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13
3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 14
3.5.3 Нэмэлт төсөв: ..... 15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ..... 15
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 15
4.1 Ерөнхий зүйл ..... 15
4.2. Материаллаг байдал ..... 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ..... 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 18
5.1 Төлбөрийн акт ..... 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 20

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| ААН | Аж ахуй нэгж |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУГ | Боловсрол, шинжлэх ухааны газар |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХҮДЭР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.МӨНХНАРАН ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/113/НА-СТА-ТШЗ

танай ______________-ны № ________________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Хүдэр сумын ЗДТГ-аас 10,000.0 мянган төгрөгийн, Дэлхийн зөн ОУБ-аас 17,401.8 мянган төгрөгийн, аймгийн БГ-аас 42,406.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.



432502106

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

*/төгрөгөөр/*

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 224,178,024.57 | 387,952,107.55 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 118,332,280.72 | 267,869,400.20 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 118,332,280.72 | 267,869,400.20 |
| 3121 | Төгрөг | 118,332,280.72 | 267,869,400.20 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 118,332,280.72 | 267,869,400.20 |
| 33 | АВЛАГА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 105,845,743.85 | 120,082,707.35 |
| 354 | Хангамжийн материал | 105,845,743.85 | 120,082,707.35 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 1,615,000.00 | 1,615,000.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 55,960,560.00 | 55,960,560.00 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 3546 | Хүнсний материал | 4,550,223.58 | 2,735,801.58 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 40,219,960.27 | 56,271,345.77 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,606,193,092.77 | 1,651,524,721.13 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,606,193,092.77 | 1,651,524,721.13 |
| 392 | Биет хөрөнгө | 1,587,945,092.77 | 1,633,276,721.13 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,440,491,894.78 | 1,440,491,894.78 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -140,470,199.34 | -167,438,659.11 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -2,916,666.69 | -4,166,666.66 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 261,859,495.65 | 303,103,325.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -137,103,979.43 | -108,118,718.70 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 86,961,300.44 | 93,025,101.04 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -35,004,254.16 | -26,776,744.79 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 139,384,204.92 | 139,134,704.92 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -58,986,123.42 | -66,909,560.52 |
| 39217 | Ном | 28,729,420.02 | 25,932,045.02 |
| 393 | Биет бус хөрөнгө | 18,248,000.00 | 18,248,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,248,000.00 | 18,248,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,830,371,117.34 | 2,039,476,828.68 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 209,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 209,000.00 |
| 413 | Өглөг | | 209,000.00 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 209,000.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,830,371,117.34 | 2,039,267,828.68 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,830,371,117.34 | 2,039,267,828.68 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 439,352,988.00 | 439,352,988.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 439,352,988.00 | 439,352;988.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -234,623,033.83 | -25,726,322.49 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | -234,623,033.83 | -234,623,033.83 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 208,896,711.34 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,625,641,163.17 | 1,625,641,163.17 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,830,371,117.34 | 2,039,476,828.68 |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

*/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,670,097,495.55 | 2,500,754,449.83 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 52,566,873.32 | 85,868,898.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 52,566,873.32 | 85,868,898.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 28,000.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 31,551,001.22 | 69,808,125.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 20,987,872.10 | 16,060,773.50 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,617,530,622.23 | 2,414,885,551.33 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,427,740,798.00 | 2,219,635,952.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,427,740,798.00 | 2,219,635,952.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 189,599,115.23 | 195,249,599.33 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 189,599,115.23 | 195,249,599.33 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 190,709.00 | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,643,068,153.08 | 2,288,392,312.77 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,643,068,153.08 | 2,288,392,312.77 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,551,159,462.18 | 2,180,419,787.97 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,084,760,229.55 | 1,599,814,283.22 |
| 210101 | Үндсэн цалин | 753,524,479.41 | 943,359,611.62 |
| 210102 | Нэмэгдэл | 270,363,088.12 | 556,903,344.49 |
| 210104 | Урамшуулал | 60,872,662.02 | 99,551,327.11 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 138,108,705.66 | 192,776,382.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 91,242,875.78 | 131,264,040.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,730,142.29 | 16,005,108.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,038,349.19 | 8,084,637.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,772,738.03 | 7,526,479.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,324,600.37 | 29,896,117.29 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 181,709,115.23 | 187,356,999.33 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,862,264.55 | 4,173,547.99 |
| 210302 | Түлш, халаалт | 158,230,050.68 | 158,245,051.34 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,616,800.00 | 24,938,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| 2105 | Нормативт зардал | 20,342,838.00 | 17,831,161.20 |
| 210502 | Хоол, хүнс | 20,342,838.00 | 17,828,161.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 3,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,074,400.00 | 7,892,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,074,400.00 | 7,892,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,709,049.94 | 31,442,483.35 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,518,000.00 | 3,528,898.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,191,049.94 | 27,913,585.35 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 102,455,123.80 | 143,305,878.62 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,532,868.98 | 59,668,107.70 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,802,798.00 | 15,780,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 60,119,456.82 | 67,857,370.92 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 91,908,690.90 | 107,972,524.80 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 91,908,690.90 | 107,972,524.80 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 67,775,350.90 | 81,370,854.80 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 24,133,340.00 | 26,601,670.00 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 27,029,342.47 | 212,362,137.06 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 3,465,425.72 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 3,465,425.72 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -3,465,425.72 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 27,029,342.47 | 208,896,711.34 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,617,558,622.23 | 2,414,885,551.33 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 28,000.00 | |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 28,000.00 | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | |
| 120009 | Бусад орлого | 28,000.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,617,530,622.23 | 2,414,885,551.33 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,427,740,798.00 | 2,219,635,952.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,427,740,798.00 | 2,219,635,952.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 189,599,115.23 | 195,249,599.33 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 189,599,115.23 | 195,249,599.33 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 190,709.00 | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,635,286,881.68 | 2,218,502,131.85 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,635,286,881.68 | 2,218,502,131.85 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,540,914,874.18 | 2,112,985,246.85 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,086,615,582.47 | 1,599,804,895.22 |
| 210101 | Үндсэн цалин | 736,731,061.68 | 943,350,223.62 |
| 210102 | Нэмэгдэл | 287,929,177.74 | 556,903,345.26 |
| 210104 | Урамшуулал | 61,955,343.05 | 99,551,326.34 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 136,253,352.74 | 192,567,382.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,477,313.37 | 130,846,040.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,248,697.12 | 16,005,108.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,883,140.71 | 8,084,637.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,103,202.67 | 7,526,479.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,540,998.87 | 30,105,117.29 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 181,709,115.23 | 187,356,999.33 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,862,264.55 | 4,173,547.99 |
| 210302 | Түлш, халаалт | 158,230,050.68 | 158,245,051.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,616,800.00 | 24,938,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| 2105 | Нормативт зардал | 22,114,085.00 | 18,472,379.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,114,085.00 | 18,472,379.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,890,000.00 | 7,892,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,890,000.00 | 7,892,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,249,049.94 | 34,887,483.35 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,518,000.00 | 3,528,898.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,731,049.94 | 31,358,585.35 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,083,688.80 | 72,003,507.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 81,680,890.80 | 56,540,157.70 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,402,798.00 | 15,463,350.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 94,372,007.50 | 105,516,885.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 94,372,007.50 | 105,516,885.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 70,238,667.50 | 78,915,215.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 24,133,340.00 | 26,601,670.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | -17,728,259.45 | 196,383,419.48 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | | 46,846,300.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 46,846,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 46,846,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | -46,846,300.00 |
| 145 | Бусад эх үүсвэр | | |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | | |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -17,728,259.45 | 149,537,119.48 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 118,332,280.72 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 267,869,400.20 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 439,352,988.00 | 1,625,641,163.17 | -234,623,033.83 | 1,830,371,117.34 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 208,896,711.34 | 208,896,711.34 |
| **19** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **439,352,988.00** | **1,625,641,163.17** | **-25,726,322.49** | **2,039,267,828.68** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,533,217,832.05 | 2,265,348,431.85 | 267,869,400.20 | 89.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,533,217,832.05 | 2,218,502,131.85 | 314,715,700.20 | 87.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,418,681,032.05 | 2,112,985,246.85 | 305,695,785.20 | 87.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,741,812,084.72 | 1,599,804,895.22 | 142,007,189.50 | 91.9 |
| 210101 | Үндсэн цалин | 1,069,036,901.95 | 943,350,223.62 | 125,686,678.33 | 88.2 |
| 210102 | Нэмэгдэл | 586,680,582.77 | 556,903,345.26 | 29,777,237.51 | 94.9 |
| 210104 | Урамшуулал | 86,094,600.00 | 99,551,326.34 | -13,456,726.34 | 115.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 344,259,700.00 | 192,567,382.25 | 151,692,317.75 | 55.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 152,465,000.00 | 130,846,040.35 | 21,618,959.65 | 85.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 137,983,300.00 | 16,005,108.57 | 121,978,191.43 | 11.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,968,600.00 | 8,084,637.04 | 883,962.96 | 90.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,968,600.00 | 7,526,479.00 | 1,442,121.00 | 83.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 35,874,200.00 | 30,105,117.29 | 5,769,082.71 | 83.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 187,356,999.33 | 187,356,999.33 | | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,173,547.99 | 4,173,547.99 | | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 158,245,051.34 | 158,245,051.34 | | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 24,938,400.00 | 24,938,400.00 | | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | | | |
| 2105 | Нормативт зардал | 25,823,200.00 | 18,472,379.00 | 7,350,821.00 | 71.5 |
| 210502 | Хоол, хүнс | 25,823,200.00 | 18,472,379.00 | 7,350,821.00 | 71.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,892,600.00 | 7,892,600.00 | | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,892,600.00 | 7,892,600.00 | | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 38,265,898.00 | 34,887,483.35 | 3,378,414.65 | 91.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,528,898.00 | 3,528,898.00 | | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 34,737,000.00 | 31,358,585.35 | 3,378,414.65 | 90.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 73,270,550.00 | 72,003,507.70 | 1,267,042.30 | 98.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,746,450.00 | 56,540,157.70 | 206,292.30 | 99.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,524,100.00 | 15,463,350.00 | 1,060,750.00 | 93.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 114,536,800.00 | 105,516,885.00 | 9,019,915.00 | 92.1 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 114,536,800.00 | 105,516,885.00 | 9,019,915.00 | 92.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 87,926,200.00 | 78,915,215.00 | 9,010,985.00 | 89.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,610,600.00 | 26,601,670.00 | 8,930.00 | 100.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 46,846,300.00 | -46,846,300.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | | 46,846,300.00 | -46,846,300.00 | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,533,217,832.05 | 2,414,885,551.33 | 3,528,898.00 | 99.9 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,334,439,334.72 | 2,219,635,952.00 | | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,219,635,952.00 | 2,219,635,952.00 | | 100.0 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 114,803,382.72 | | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 195,249,599.33 | 195,249,599.33 | | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 195,249,599.33 | 195,249,599.33 | | 100.0 |
| 133 | ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС | | | | |
| 134 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | | | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 3,528,898.00 | | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,528,898.00 | | | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 118,332,280.72 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 267,869,400.20 | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь "*Хамтын оролцоог дэмжиж, эрүүл аюулгүй орчинг бий болгон суралцахуйн хөгжил төлөвшил чанарт ахиц гаргана*" гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагчийн эзэмших чадамжийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо хамтын ажиллагааг хангах;
- Ёс зүйг эрхэмлэж, багшлахуй ба суралцахуйн хөгжил, төлөвшил, үр дүн, чанарт ахиц гаргах;
- Эрүүл аюулгүй орчинг бий болгох;

### 3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл,үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор"Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл,чанар,үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт,

шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 209,105.7 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн | Өөрчлөлт |
|---|---|---|---|

| | | үлдэгдэл | |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 118,332.3 | 267,869.4 | 149,537.1 |
| Бараа материал | 105,845.7 | 120,082.7 | 14,237.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,606,193.1 | 1,651,524.7 | 45,331.6 |
| **Нийт хөрөнгө** | **1,830,371.1** | **2,039,476.8** | **209,105.7** |
| Өглөг | - | 209.0 | 209.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,830,371.1 | 2,039,267.8 | 208,896.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,830,371.1** | **2,039,476.8** | **209,105.7** |

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 267,869.4 мянган төгрөг болж 149,537.1 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 -д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Бараа материал дансны үлдэгдэл 120,082.7 мянган төгрөг болж 14,237.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 151,825.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУЯ-наас 16,060.8 мянган төгрөгийн түрээсийн ном үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, үйл ажиллагаанд 153,649.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,024,935.1 мянган төгрөг болж 44,260.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 46,846.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, сумын ЗДТГ-аас 10,000.0 мянган төгрөгийн, Дэлхийн зөн ОУБ-аас 17,401.8 мянган төгрөгийн, аймгийн БГ-аас 42,406.3 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн зэрэг нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 373,410.4 мянган төгрөг бөгөөд 1,651,524.7 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.
- Өр төлбөр дансанд 209.0 мянган төгрөгийн өглөг шинээр үүссэн нь төлбөр тооцоог хянаагүйгээс нийгмийн даатгалын байгууллагад 209.0 мянган төгрөгийг илүү шилжүүлснээс шалтгаалсан байна.

### 3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,523,360.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 195,249.6 мянган төгрөг, нийт 1,718,609.8

мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 11,814.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 8,180.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 29,994.0 мянган төгрөгөөр нийт 49,989.1 мянган төгрөгөөр бууруулж төсвийг 1,668,620.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 9 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 2,219,635.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 195,249.6 мянган төгрөгийн, оны эхний үлдэгдлээс 114,803.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 3,528.9 мянган төгрөг нийт 2,533,217.8 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 800,354.2 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 10,751.1 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,528.9 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 4,743.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 9,585.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 35,634.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн гэх мэт

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 2,533,217.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 2,265,348.4 мянган төгрөгийг зарцуулж, 267,869.4 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,265,348.4 мянган төгрөг буюу 89.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| д/д | Хөтөлбөр | д/д | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **71802 Ерөнхий боловсрол** | 1 | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ | 4,100.6 | 4,085.3 | 15.4 | 99.6 |
| | | 2 | 80233-Хүүхэд хамгаалал | 4,362.6 | 3,889.8 | 472.8 | 89.2 |
| | | 3 | 80312- Сургалт семнар | 3,135.1 | 1,196.0 | 1,939.1 | 38.1 |
| | | 4 | 81605- Эрүүл мэндийг дэмжих | 6,441.9 | 5,927.6 | 514.3 | 92.0 |
| | | 5 | 81801- Үдийн цай хөтөлбөр | 87,926.2 | 78,915.2 | 9,011.0 | 89.8 |
| | | 6 | 81806-Дотуур байрны үйлчилгээ | 25,823.2 | 18,472.4 | 7,350.8 | 71.5 |
| | | 7 | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 32,365.8 | 32,365.8 | - | 100.0 |
| | | 8 | 81823- Боловсролын багшийн сургалт | 18,448.7 | 10,760.3 | 7,688.4 | 58.3 |
| | | 9 | 81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 8,819.5 | 7,030.2 | 1,789.3 | 79.7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 10 | 81834- Боловсролын стандарт сургалт | 1,999,397.9 | 1,780,348.5 | 219,049.5 | 89.0 |
| | | 11 | 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 133,145.9 | 116,964.1 | 16,181.8 | 87.8 |
| | | 14 | 80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 195,249.6 | 195,249.6 | - | 100.0 |
| | | 15 | 81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 7,420.0 | 6,614.9 | 805.1 | 89.1 |
| | **Нийт** | | | **2,533,217.8** | **2,265,348.4** | **267,816.9** | **89.4** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *"Чиглэл хүргүүлэх тухай"* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

| № | Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал | Батлагдсан төсөв | Гэрээний дүн | Тендер шалгаруулалтын арга |
|---|---|---|---|---|
| 1 | Үдийн цай | 78,902.1 | 78,902.1 | НТШ |
| | **Нийт дүн** | **78,902.1** | **78,902.1** | |

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ -ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан "Шинэ үерт" ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 15-ний өдөр гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэжээ.

Тайлант онд хоол хүнс, цэвэрлэгээний материалыг "Шинэ үерт ХХК, бичиг хэрэг, ахуйн бараа, урсгал засварын материалыг "Цахим Ертөнц" ХХК болон иргэн Мөнхбаттай тус тус худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн */цаашид Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль гэх/* 2024 оны

12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бараа материалын орлогыг төлбөр хүлээн авагчийн нэрээр авах, нягтлан бодох бүртгэлийн CTSYSTEM 6.5 программ хангамжийг хөрөнгийн бүртгэлд бүртгэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,642,905.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,429.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл 3 удаа;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 3 удаа;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 удаа;

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй болно.

### 4.5 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 913 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”

захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин илүү олгосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, шилэн дансны тухай хуулийн хууль тогтоомжтой холбоотой зөрчлийг давтан гаргасан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 4,072.4 | 1 | 4,072.4 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | | 1 | | 50.0 |
| **Нийт дүн** | **3** | **4,072.4** | **2** | **4,072.4** | **75.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 46,846.3 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Худалдан авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлаар бүртгэсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 5,239.1 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч 1,083.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 209.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 3,946.3 мянган төгрөгийн болон биет бус хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зэрэг 2 зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

1.Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус сумын 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар захирал Д.Мөнхнарангийн ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь “*Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх* ", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.11 дэх "*Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана*" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

**5.2 Албан шаардлага**

2.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 209.0 мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**5.2 Зөвлөмж**

***1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал***

1.1 Илрүүлэлт: Худалдан авсан 3,946.3 мянган төгрөгийн бараа материалыг төлбөр гүйцэтгэгчийн нэрээр бус хамаарал бүхий этгээдийн нэрээр орлого авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*" гэсэн заалтыг зөрчсөн байна..

1.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн орлогыг төлбөр хүлээн авагчийн нэрээр авч, өглөг авлага үүсгэх эрсдэл үүсэхээс сэргийлэх;

***2. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал***

2.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн CTSYSTEM 6.5 программ хангамжийг ашигласан цагаас эхлэн биет бус хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-д "*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамжийг биет бус хөрөнгийн бүртгэлд бүртгэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлаар бүртгэсэн | 1 | 46,846.3 | | | 1 | 46,846.3 | 1 | 46,846.3 | | | | |
| **Дүн** | 1 | 46,846.3 | | | 1 | 46,846.3 | 1 | 46,846.3 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Захиралд шагнал олгосон | 1 | 1,083.8 | 1 | 1,083.8 | | | | | | | | |
| Өр төлбөр үүсгэсэн | 1 | 209.0 | | | 1 | 209.0 | | | | | | |
| Хөрөнгийн орлогыг төлбөр гүйцэтгэгчийн нэрээ бус хамаарал бүхий этгээдийн нэрээр авсан | 1 | 3,946.3 | | | | | 1 | 3,946.3 | | | | |
| Санхүүгийн програм хангамжийг хөрөнгөөр бүртгээгүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **4** | **5,239.1** | **1** | **1,083.8** | **1** | **209.0** | **2** | **3,946.3** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны 7 мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлсэн. | 1 | - | | | 1 | | | |
| **Дүн** | **1** | **-** | | | | | **1** | **-** |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 23/А1850385 Сүхбаатар

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус сумын 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар захирал Д.Мөнхнарангийн ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх “, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт ”Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.11 дэх “Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т “*Төлбөрийн акт*

432505069

*тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.* 4.2.3.2: *Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урамшуулалд олгосон 1,083.8 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Мөнхнаран, нягтлан бодогч Х.Мөнгөнцэцэг нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

АУДИТОР Б.НАРАНЧИМЭГ

## Албан шаардлага, <u>төлбөрийн актын</u> бүртгэл, хяналтын хуудас

### А. Албан шаардлага, <u>төлбөрийн актын</u> төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл хяналт

### 1. Үндсэн мэдээлэл

| | | | |
|---|---|---|---|
| 1.1 Аудитын нэр | Сэлэнгэ аймгийн Хүдэр ЕБС-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | 1.2 Аудитын код | СЭА-2025/113/НА-СТА-ТШЗ |
| 1.3 Аудит хийх үндэслэл | Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1 | 1.4 Аудитын төрөл | Санхүүгийн тайлангийн аудит |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.5 Албан шаардлага, төлбөрийн актын дугаар | 93........./А1850385 СЭА-2025/113-НА-СТА-ТШЗ | 1.6 Тогтоосон огноо | 2/24/2025 | 1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/ | 1,083,800.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл | Зөрчил дутагдлыг товч тодорхойлж бичих | | Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар захирал Д.Мөнхнарангийн ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай |
| | Алдаа, зөрчлийн ангилал | | Төлбөрийн акт |
| | Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах) | | Журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” |
| | Зөрчсөн эрх зүйн актын | Нэр | Төсвийн тухай хууль |
| | | Заалт | 6.6.2 |
| | | Нэр | Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол |
| | | Заалт | 3 дугаар хавсралт |
| | Үндэслэл болгосон эрх зүйн актын | Нэр | Төрийн аудитын тухай хууль, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”, |
| | | Заалт | Хуулийн 21.2, журмын 4.2.3, 4.2.3.3, |

| | | | |
|---|---|---|---|
| 1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / Төгрөгөөр/ | Улсын төсвийн дансанд | | 1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо |
| | Орон нутгийн төсвийн дансанд | 1,083,800.0 | |
| | Тухайн байгууллагын дансанд | | |
| | | | 6/15/2025 |

### 2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

| № | Нотлох баримтын төрөл | Дугаар | Огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Цалингийн баримт, | | 2024 он | |
| 2 | Сумын ЗД-ын захирамж | | 2024 он | |

### 3 Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

| Аудитын багийн | | Хариуцагч | | | |
|---|---|---|---|---|---|
| Овог нэр | Албан тушаал | Байгууллагын нэр | Албан тушаал | Овог нэр | Холбоо барих утас |
| Б.Наранчимэг | Аудитор | Хүдэр сумын ЕБС | Захирал | Д.Мөнхнаран | 99519792 |
| | | | Нягтлан бодогч | Х.Мөнгөнцэцэг | 88323282 |

### 4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

#### 4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

| № | Албан тушаалтан | Огноо | Чанарын хяналтаар өгсөн санал, зөвлөмж | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Аудитын менежер | [handwritten date] | — | [signature] |
| 2 | Тэргүүлэх аудитор | 11/25 | — | [signature] |

#### 4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

| № | Албан тушаал | Овог нэр | Огноо | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Тэргүүлэх аудитор | 11/25 | | [signature] |

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

| № | Үзүүлэлт | | | Мэдээлэл оруулах хэсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын | | Огноо | | |
| | | | Дугаар | | |
| 2 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн | | Огноо | | |
| | | | Дугаар | | |
| 3 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн | Огноо | | 2/24/2025 | |
| | | Ажилтны | Овог нэр | Б.Наранчимэг | |
| | | | Албан тушаал | Аудитор | |
| 4 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан | Байгууллагын нэр | | Хүдэр сумын ЕБС | |
| | | Ажилтны | Овог нэр | Х.Мөнгөнцэцэг | |
| | | | Албан тушаал | Нягтлан бодогч | |
| 5 | Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах | Байгууллагын нэр | | Пийк Ом аудит ХХК | |
| | | Ажилтны | Овог нэр | Б.Наранчимэг | |
| | | | Албан тушаал | Аудитор | |
| 6 | Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж | Санхүүгийн | Тоо | | |
| | | | Дүн | | |
| | | Санхүүгийн бус үр өгөөж | | | |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 74/А1850385 Сүхбаатар

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд 7 мэдээллийг хугацаа хоцроож, зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл 3 удаа;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 3 удаа;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 удаа;

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "*Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх*" гэсэн заалт болон уг хуулийн 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*" журмын 4.2.1-д "*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн* заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Мөнхнаран, нягтлан бодогч Х.Мөнгөнцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч. ЭНХТУЯА

АУДИТОР Б.НАРАНЧИМЭГ

432504221

*Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09 өдрийн А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт*

## АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

**А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт**

1.Ерөнхий мэдээлэл

| | | | |
|---|---|---|---|
| 1.1 Аудитын нэр | Сэлэнгэ аймаг Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | 1.2 Аудитын код | СЭА-2025/113/НА-СТА-ТШЗ |

| | | | |
|---|---|---|---|
| 1.3 Аудит хийсэн үндэслэл | Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1 | 1.4 Аудитын төрөл | Санхүүгийн тайлангийн аудит |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар | 07.../А1850385 СЭА-2025/113/НА-СТА-ТШЗ | 1.6 Огноо | 2025.02.24 | 1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл | Алдаа зөрчлийн товч утга | Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд 7 мэдээллийг хугацаа хоцроож, зөрчлийг давтан гаргасан байна | |
| | Алдаа зөрчлийн ангилал | Хууль, тогтоомж зөрчсөн | |
| | Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах) | 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол | |
| | Зөрчсөн эрх зүйн актын | Нэр | Шилэн дансны тухай хууль |
| | | Заалт | 4.1.3 |
| | Үндэслэл болгосон эрх зүйн актын | Нэр | Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал |
| | | Заалт | 4.2.1.9, 4.2.1.11 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/ | Улсын төсвийн дансанд | | 1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо |
| | Орон нутгийн төсвийн дансанд | | |
| | Тухайн байгууллагын дансанд | | |
| | | | |

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

| № | Нотлох баримтын нэр төрөл | Дугаар | Огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Шилэн дансны цахим сан | | 2024 он | |
| | | | 2024 он | |

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

| № | Аудитын багийн | | Хариуцагч | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Овог нэр | Албан тушаал | Байгууллагын нэр | Албан тушаал | Овог нэр | Холбоо барих хаяг, утас |
| 1 | Б.Наранчимэг | Аудитор | Хүдэр сумын ЕБС | Захирал | Д.Мөнхнаран | 99519792 |
| | | | | Нягтлан бодогч | Х.Мөнгөнцэцэг | 88323282 |

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

| № | Албан тушаалтан | Огноо | Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Тэргүүлэх аудитор | II/25 | — | [signature] |
| 2 | Аудитын менежер | II/25 | — | [signature] |

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

| № | Албан тушаал | Овог нэр | Огноо | Гарын үсэг |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Тэргүүлэх аудитор | Ч.Энхтуяа | 11/25 | |
| 2 | | | | |

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

| № | Үзүүлэлт | | | Мэдээлэл оруулах хэсэг | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын | | Огноо | | |
| | | | Дугаар | | |
| 2 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн | | Огноо | | |
| | | | Дугаар | | |
| 3 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн | Огноо | | 2025.02.24 | |
| | | Ажилтны | Овог нэр | Б.Наранчимэг | |
| | | | Албан тушаал | Аудитор | |
| 4 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан | Байгууллагын нэр | | Хүдэр сумын ЕБС | |
| | | Ажилтны | Овог нэр | Х.Мөнгөнцэцэг | |
| | | | Албан тушаал | Нягтлан бодогч | |
| 5 | Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах | Газрын нэр | | Пийк Ом Аудит ХХК | |
| | | Ажилтны | Овог нэр | Б.Наранчимэг | |
| | | | Албан тушаал | Аудитор | |
| 6 | Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж | Санхүүгийн | Тоо | | |
| | | | Дүн | | |
| | | Санхүүгийн бус үр өгөөжийн тоо | | | |

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 43/А1850385 Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 209.0 мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох"* журмын 4.2.1-д *"Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11: "Хууль тогтоомж, ......зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилган давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Мөнхнаран, нягтлан бодогч Х.Мөнгөнцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

АУДИТОР Б.НАРАНЧИМЭГ

43250421З

*Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09 өдрийн А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт*

**АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС**

**А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт**

1.Ерөнхий мэдээлэл

| | | | |
|---|---|---|---|
| 1.1 Аудитын нэр | Сэлэнгэ аймаг Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | 1.2 Аудитын код | СЭА-2025/113/НА-СТА-ТШ3 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.3 Аудит хийсэн үндэслэл | Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1 | 1.4 Аудитын төрөл | Санхүүгийн тайлангийн аудит |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар | 73/...А1850285 СЭА-2025/113/НА-СТА-ТШ3 | 1.6 Огноо | 2025.02.24 | 1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/ | 209,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.8 Албан шаардоага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл | Алдаа зөрчлийн товч утга | Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 209.0 мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн байна | |
| | Алдаа зөрчлийн ангилал | Хууль, тогтоомж зөрчсөн | |
| | Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах) | 4.2.1.11: "Хууль тогтоомж, ……зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал | |
| | Зөрчсөн эрх зүйн актын | Нэр | Төсвийн тухай хууль |
| | | Заалт | 6.4.8 |
| | Үндэслэл болгосон эрх зүйн актын | Нэр | Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал |
| | | Заалт | 4.2.1.9, 4.2.1.11 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/ | Улсын төсвийн дансанд | | 1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо | |
| | Орон нутгийн төсвийн дансанд | | | |
| | Тухайн байгууллагын дансанд | | | |
| | | | | |

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

| № | Нотлох баримтын нэр төрөл | Дугаар | Огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Бараа материалын тайлан | | 2024 он | |
| 2 | Харилцахын баримт | | 2024 он | |

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

| № | Аудитын багийн | | Хариуцагч | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Овог нэр | Албан тушаал | Байгууллагын нэр | Албан тушаал | Овог нэр | Холбоо барих хаяг, утас |
| 1 | Б.Наранчимэг | Аудитор | Хүдэр ЕБС | Захирал | Д.Мөнхнаран | 99519792 |
| | | | | Нягтлан бодогч | Х.Мөнгөнцэцэг | 88323282 |

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

| № | Албан тушаалтан | Огноо | Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Тэргүүлэх аудитор | 11/25 | – | [signature] |
| 2 | Аудитын менежер | 11/25 | – | [signature] |

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

| № | Албан тушаал | Овог нэр | Огноо | Гарын үсэг |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Тэргүүлэх аудитор | Ч.Энхтуяа | II/25 | |
| 2 | | | | |

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

| № | Үзүүлэлт | | | Мэдээлэл оруулах хэсэг | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын | | Огноо | | |
| | | | Дугаар | | |
| 2 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн | | Огноо | | |
| | | | Дугаар | | |
| 3 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн | Огноо | | 2025.02.24 | |
| | | Ажилтны | Овог нэр | Б.Наранчимэг | |
| | | | Албан тушаал | Аудитор | |
| 4 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан | Байгууллагын нэр | | Хүдэр ЕБС | |
| | | Ажилтны | Овог нэр | Х.Мөнгөнцэцэг | |
| | | | Албан тушаал | Нягтлан бодогч | |
| 5 | Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах | Газрын нэр | | Пийк Ом Аудит ХХК | |
| | | Ажилтны | Овог нэр | Б.Наранчимэг | |
| | | | Албан тушаал | Аудитор | |
| 6 | Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж | Санхүүгийн | Тоо | | |
| | | | Дүн | | |
| | | Санхүүгийн бус үр өгөөжийн тоо | | | |